БАТЛАВ. СУМЫН ЗАСАГ ДАРГА............ Т. ЭРДЭНЭБАТ

## ТЭЭВЭР/ ШАТАХУУН /-НЫГ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Төмөрбулаг сум № 01 2019 оны 02 сарын..18..

### НЭГ. Гэрээний зорилго

Энэхүү гэрээг нэг талаас Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч А. Амаржаргал /цаашид Захиалагч гэх/, нөгөө талаас Баян Энх Айраг ХХК – ны захирал Ц. Эрдэнэдоо /цаашид бэлтгэн нийлүүлэгч гэх/ нар гэрээний хавсралт дээр дурдсан бараа бүтээгдэхүүнүүдийг худалдан авах, төлбөр тооцоог хэрхэн барагдуулах, цаашид хамтран ажиллахаар байгуулав. \ барааны нэр, too ширхэгийг хавсралт болгов.\

Монгол Улсын Иргэний хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу олон нийтийн оролцоотойгоор бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдон захиалагч нийлүүлэгчийн хооронд үүссэн харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

### ХОЁР. Бэлтгэн нийлүүлэгчийн хүлээх хариуцлага

2.1.Бэлтгэн нийлүүлэгч нь гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан нэр төрлийн бүтээгдэхүүнийг заасан тоо хэмжээ, чанар болон тогтоосон хугацаанд бэлтгэн худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэн өгнө.

2.2. Нийлүүлж байгаа бүтээгдэхүүн нь чанар сайтай байхаас гадна зөвшөөрлийн бичигтэй байна.

2.3. Бүтээгдэхүүний чанар хангалтгүй байсан тохиолдолд падаанаас хасч тооцох буюу ижил төрлийн бараагаар захиалагчийн анхны шаардлагын дагуу сольж өгөх үүрэгтэй

2.4. Бүтээгдэхүүнийг захиалагчид цаг тухай бүрт нь чирэгдэлгүй өгөх асуудлыг нийлүүлэгч тал бүрэн хариуцах бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

2.5. Нийлүүлэгч тал бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгөх дээ эрх бүхий албан тушаалтны гарын үсэг тамга тэмдэгээр баталгаажсан баримт бичгийн дагуу олгоно.

### ГУРАВ.Захиалагчийн үүрэг

3.1 Захиалагч тал барааг хүлээн авахдаа цэцэрлэгийн эрхлэгч болон ня-бо нарын гарын үсэг,тамга тэмдэгээр баталгаажуулсан баримт бичгээр хүлээн авна.

3.2 Төлбөр тооцоог хийхдээ падааны мөнгөн дүн, хугацаа,он сар,зориулалтыг тодорхой бичиж гарын үсэг, тамга тэмдэгийг гаргацтай бичсэн байна.

3.3 Захиалагч тал нийлүүлэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

**ДӨРӨВ .Гэрээний үнэ**

4.1 Бэлтгэн нийлүүлж буй бүтээгдэхүүний үнэ ...1470.000... Нэг сая дөрвөн зуун долоон мянган төгрөг ........ / төгрөг ба уг төлбөрийг гэрээнд заасан хугацаанд Баян энх айраг ХХК –д 100% төлж барагдуулна.

**ТАВ.Тооцооны журам**

6.1 Төлбөр төлөх эцсийн хугацаа 2019 оны 12 сарын 31-ныг гэхэд 100% төлж барагдуулсан байна.

6.2 Хэрэв гэрээнд заагдсан хугацаанд гэрээний үнийн дүн биелэгдээгүй үүргийн үнийн дүнгээс хоног тутамд 0.25% алданги тооцож нийлүүлэгч талд олгоно.

6.3 Төлбөр төлөх эцсийн хугацаанд захиалагч бүтээгдэхүүнийг худалдан авах шаардлагагүй бол дансанд мөнгө үлдэж болно.

**ЗУРГАА .Өмчлөх эрх**

7.1. Барааг өмчлөх эрх нь төлбөр бүрэн төлөгдсөн үед бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авагчид шилжинэ. Төлбөр бүрэн төлөгдөөгүй үед барааг эзэмших эрх бэлтгэн нийлүүлэгчид байна.

**ДОЛОО. Нэмэлт нөхцөл**

8.1 Хэрэглэгчийн буруутай үйлдлээс гарсан гэмтэлүүд /алдах, хэрэглэх боломжгүй болох, андуурч буруу шатахуун хийлгэсэн гм/ нийлүүлэгч талд хамаарахгүй.

**НАЙМ . Маргаан шийдвэрлэх**

10.1 Маргаан үүссэн тохиолдолд талууд хэлэлцээ хийх замаар зохицуулна.

10.2 Маргааныг хэлэлцээ хийх замаар шийдвэрлэж чадахгүйд хүрвэл хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

10.3 Талууд энэхүү гэрээнд заасан нөхцлийг урьдчилан гүйцэт уншиж танилцсан байх ба гэрээний бүх нөхцлийн талаар харилцан тохиролцсон бөгөөд талууд бүрэн ойлголт тохиолдолд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна. Гэрээг 2 хувь үйлдэж нийлүүлэгч талд 1%-ийг өгнө.

**ЕС . БАТАЛГААЖУУЛАЛТ**

| Бэлтгэн нийлүүлэгч: | Захиалагч: |
|---|---|
| Төмөрбулаг сум Баян Энх айраг ХХК-ны | Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн |
| Захирал ..........Ц. Эрдэнэдоо | эрхлэгч...........А.Амаржаргал |
| \гарын үсэг,тамга\ | \гарын үсэг,тамга\ |
| Утас 89998133 | Утас: 88263506,99387105 |

Гэрээний хавсралт 1

Захиалагч, нийлүүлэгч байгууллага хоёрын хооронд гэрээгээр хүлээн зөвшөөрсөн үнийн санал:

| № | Бүтээгдэхүүний нэр | Хэмжих нэгж | Тоо ширхэг /манай хэрэгцээнд | Нэг бүрийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Бензин А\80 | л | 600 | 1800 | 1080000 |
| 2 | Дизель түлш | л | 162.5 | 2400 | 390000 |
| | Дүн | | | | 1470000 |

Баян-энхайраг ХХК-ны захирал ..........Д.Эрдэнэдоо

Цэцэрлэгийн эрхлэгч ......................А.Амаржаргал